

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-21

1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 7-10

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./ 10-19

3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/ 19

4.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/ 19-21

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 08 дугаар сарын 21-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 36 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Пүрэвдорж;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, С.Бямбацогт, Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хэлэлцэх асуудлын дараалалд “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дөрөвдүгээр асуудал болгон хэлэлцэх горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэхээр тогтов.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга Б.Батцэцэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилиг, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын менежер Ю.Энхтуяа, Л.Мөнхцацрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн П.Энхманлай, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын менежер Ю.Энхтуяа, Л.Мөнхцацрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлах хянагч шалгагч Т.Нармандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

3.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

4.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
16 цаг 36 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааныг эхлүүлэе. Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ амрыг эрье.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. 25 гишүүнээс 14 гишүүн. Ирц 56 хувьтай байгаа тул хуралдааныг эхлүүлэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх бүрэлдэж, ирц 56 хувьтай бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Ингээд хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд. Мөн энэ төслийн хоёр дахь хэлэлцүүлэг.

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, анхны хэлэлцүүлэг.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал байна.

Хэлэлцэх асуулттай холбоотой саналтай гишүүд байна уу? Саналаа өгөөрэй.

Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Сандаг-очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Зарчмын санал байна Байнгын хорооны даргаа, энэ өнөөдөр сахил хүртээд шал дордов гэдэг шиг 76 байж байгаад 126 болсон биш Байнгын хорооны хурал 5 цаг ингэж хойшилж байсан түүх байхгүй байна шүү дээ. Тэгээд энд чинь Байнгын хорооны гишүүдийн чинь дийлэнх олонх нь дандаа шинээр сонгогдсон гишүүд байгаа.

Гэтэл энэ чинь үйл ажиллагааны хөтөлбөр 4 жилийн, тэгээд төсвийн тодотгол хийх гээд байгаа шүү дээ уг нь бол. Нээх хүндрэлтэй асуудал байхгүй. Ингээд бушуухан энэ үйл ажиллагааны хөтөлбөр, тодотгол юмыг нь батлаад, тэгээд энэ Засгийн газрыг ажилд нь оруулмаар байгаа юм. Энэ дээр ингээд цаг бараад л их аймаар ингээд л жигтэйхэн олон зарчмын зөрүүтэй танин мэдэхүйн асуултууд асуугаад л ингээд л цаг барж байгаа асуудлууд их байна. Яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд анхнаасаа энэ чинь дөнгөж ээлжит бус чуулган ч эхлээгүй, анхны ээлжит бус чуулган дээр ингээд гишүүд нь ирц бүрдэхгүй шалтгаанаар ингээд 4, 5 цаг хүлээлгэдэг юм гэж юу байх вэ дээ. Тэгээд цаашидаа 4 жил ингээд ийм байдалтай яаж явах юм.

Тэгэхээр анхнаасаа энэ гишүүдийнхээ ёс зүйн асуудал, хурал чуулгандаа цагаа барьдаг асуудлыг анхнаас нь хатуухан байдлаар явахгүй бол энэ чинь. Мэдэхгүй энэ ийм байдалтай цаашидаа энэ хуралдаан явахад хүндрэлтэй байна шүү дээ. Тэгээд

энэ олон төрийн байгууллагуудыг 5 цаг хүлээлгэж байна шүү дээ. Яг үнэн эд нар чинь ч гэсэн аргаа барж байна шүү дээ. Ажлаа, 1 өдрийн ажил алдаж байна шүү дээ. Бүхэл бүтэн. Тэгээд л орж ирээд ирц бүрдүүлчхээд л гараад явчихдаг. Одоо хар л даа 25 хүнээс одоо хэд байна? 14. 14-өөс одоо тал нь сууж байна шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Ийм байдалтай байвал цаашидаа ер нь бас энэ төрийн ажил, Улсын Их Хурал өөрөөсөө эхлэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд нөгөө сайхан шинэ гишүүд орж ирсэн гээд байсан хаа байна? Шажигначихлаа ингээд асуудлаа түргэн шуурхай шийдээд явъя гэсэн чинь хаа байна? Ийм байдалтай. Анхнаасаа ийм үлбэгэр сул ингэж эхэлбэл энэ 4 жил бас ажил явахад хүндрэлтэй л юм шиг харагдаж байна.

Тийм учраас цаашидаа Байнгын хорооны дарга нар нь ирсэн, ирээгүйгээр нь энэ цаг юмыг нь зарлаад, хариуцлага юм байдаг юм бол хэлж яриад тодорхой явахгүй бол бас амаргүй байна шүү гэдэг ийм зарчмын саналыг хэлмээр байна. Цаашидаа энэ хурлаараа жоохон ажил хэрэгч хурдхан явуулбал хэн хэндээ амар байна шүү л гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүний саналыг авлаа авлаа. Ер нь цаашидаа жоохон хатуухан шиг зарчим барьж явахгүй бол арай дэндээж байгаа бас.

Гэхдээ өнөөдрийн хуралдааны хувьд Бид 1 цагаас хурлаа зарлачихсан байсан. Нийгмийн бодлогын байнгын хороо 11 цагаас хойш хуралдаад сая хүртэл хуралдаж байсан. Дуусаагүй байгаа шүү. 11 цагаас, одоо хэдэн цаг болж байна? 4 цаг, 5 цаг, бараг 6 цаг хуралдаж байна шүү дээ. Тэгээд бас таны хэлсэн үгэн дотор орж байгаа тэр болсон, болоогүй асуултууд асуугаад, танин мэдэхүйн чанартай асуултууд асуугаад ингээд яваад байх шиг л харагдаад байна яг үндсэндээ бол. Тэгээд 5 цаг хуралддаг Байнгын хорооны хурал мэдэхгүй урьд өмнө асуудлуудаа хуралдаад л явж л байсан байх. Бага

гишүүд нь бас бага байсан л байх. Тэгээд энийг бодолцъё нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өнөөдөр би ирц бүрдүүлэх, сая ирсэн гишүүдийг танилцуулах ёстой. Энэ аппарат юмнууд чинь ажиллахгүй байна. Энэ техникийн хүмүүс хүрч ирж энд нэрс нь гарч ирэхгүй байгаад байгаа. Би сая хэллээ шүү дээ. 25 гишүүнээс 14 гишүүн ирж, 56 хувьтай байна гээд. Уг нь бол нэрс орж ирсэн байх ёстой. Энэ гараар гаргасан нэрс орж ирж байх шиг байна. Би зарлая.

Ж.Бат-Эрдэнэ миний бие байж байна. Д.Амарбаясгалан ирээгүй байна, О.Алтангэрэл гишүүн ирээгүй байна, Б.Батбаатар гишүүн ирээгүй байна, Шижир гишүүн ирцэд орсон бас алга, Баярбаатар гишүүн байна, Ж.Баярмаа гишүүн ирцэд орсон алга байна. Одоо нэгэнт асуудал бас дэвшигдээж л байгаагийн хувьд ирцдээ орчхоод гараад явж байгаа хүмүүсийг ингээд дуудъя дуудъя. Бямбацогт гишүүн ер нь бол ажилтай бас нэлээн хүлээж хүлээж байгаад чөлөө аваад явсан байгаа. Л.Гантөмөр ирээгүй байна, Доржханд гишүүн ирцэд орсон алга байна, С.Зулхар ирцэд орсон алга байна, Э.Болормаа гишүүн ирцэд орсон алга байна, Л.Мөнхбаатар гишүүн алга байна, Б.Найдлаа гишүүн ирцэд орсон алга байна. Өө байна байна уучлаарай. О.Номинчимэг ирцэд орсон алга байна, Н.Номтойбаяр алга, Э.Одбаяр байна, Л.Оюун-Эрдэнэ алга, Б.Пүрэвдорж гишүүн алга, Сандаг-Очир гишүүн ирсэн, Ц.Туваан гишүүн байна, Н.Учрал байна, О.Цогтгэрэл алга, Л.Энх-Амгалан гишүүн сая бас чөлөө авсан ийм байдалтай байна. Болормаа гишүүн орж ирлээ.

Ямар ч байсан бидний хувьд өнөөдөр байр, танхим байхгүй хүлээгдэж хүлээгдэж байгаад сая энд хууль зүйн юу билээ, гадаад харилцаа юу төсвийн асуудал дуусаад тэгээд бид нар орж ирж байгаа маань энэ шүү дээ.

Асуудлаа цаашаагаа танилцуулъя. Гурван асуудал байж байгаа. Сандаг-

Очир гишүүн яг хэлэлцэж буй асуудалтай холбоогүй саналыг хэллээ.

Би нэг асуудлыг бас оруулж ирж байна. “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье гэсэн ийм саналыг оруулж ирж байна. Ингээд хэлэлцэх асуудал маань 4 болж байна.

Өөр хэлэлцэх асуудал дээр, энэ асуудлыг горимын санал оруулж байж юу яах юм байна тийм үү?

Саяын миний асуудлыг, өөр санал байхгүй бол хэлэлцэх асуудлаа батлахын өмнө саяын миний оруулсан асуудал дээр горимын санал миний бие гаргаж байгаа тул санал хураалт явуулъя.

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар, “Улсын Их Хурлын гишүүний халдашигүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг. Энэ асуудлаар санал хураалт явуулъя. Энэ чинь юу байна шүү дээ. Угаасаа наад санал хураалтаараа юу яана шүү дээ. Тийм зарчмын зөрүүтэй санал оруулж ирж байгаа юм. Одоо тэгээд яах вэ дээ. Тестийнхээ саналыг явуулах уу? Санал хураалтаа. Санал хураалт.

Төхөөрөмжүүд яаж байна? Энэ саяынх чинь тестийн санал гэсэн тийм үү? Туршилтын санал гэсэн. Санал хураалт явуулъя.

Санал хураалт 64.3 хувиар санал дэмжигдлээ. Ингээд 4 асуудлыг хэлэлцэнэ. Анхныхаа асуудал руу оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Л.Гантөмөр алга байна. Монгол Улсын Шадар сайд, Доржханд сайд дөнгөж сая бас чөлөө аваад гарлаа. Энэ уулзалт хийчхээд ороод ирье гэж байх шиг байна. Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан алга байна, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал ирсэн байна. Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр ирсэн байна. Монгол Улсын сайд 20 минут Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн алга байна. Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж? Дуудаарай алга байна. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Л.Лхагвасүрэн? Алга байна. Энэ ажлын хэсгийнхнийг дуудаарай. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай ирсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга Б.Батцэцэг ирсэн байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг ирсэн байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга, бригадын генерал Д.Ариунболд? Алга байна. Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн ирсэн байсан. Ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан ирсэн байна. Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран ирсэн байна. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ? Алга байна.

Энэ ажлын хэсэг дуудах юм байна шүү дээ. Энэ хүмүүсийг. Ер нь Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Үндэсний аюулгүй байдлын

зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын Шадар сайд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний газрын Үндэсний хорооны дарга гэх мэтчилэн энэ хүмүүст хамааралтай төсвийг өнөөдөр бид бүхэн хэлэлцэж байгаа шүү. Энэ дээр анхааралтай бас ажлын хэсэгт хүмүүс оролцуулаарай.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаас танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофон өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар ийнхүү хэлэлцүүлж байна.

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувьд инфляцыг 1 оронтой тоонд зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой, эрс шийдэмгий шийдвэрүүдийг гаргаж энэ 30 жилийн хөгжлийн гарааг, шинэ 30 жилийн гарааг эхлүүлэх

хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын урт, дунд хугац хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэж эхэлсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Нийслэлийн их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол буюу Go Mongolia ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог, авто замын төсөл, Шинэ Хархорум төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

Хоёрдугаарт, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй бүсчилсэн хөгжил, Шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

Гуравдугаарт, 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ, тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах хувийн хэвшил тус бүрд хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны

өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

Тавдугаарт, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон билээ.

Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны

төсвийн тухай хуулийн төслүүдийг хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Загджав даргыг микрофонд урья. 5 номерын микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдаж Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагдах хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зардалд 247.8 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна.

Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Ингээд хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ингээд санал хураалт явуулна тийм үү? Санал хураалт байхгүй билүү? Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна тээ? Асуулт байхгүй. Тэгвэл ингээд л нэгдүгээр асуудал болох нь байна шүү дээ.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

15.05 цаг

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай, “Тогтоолын хавсралтад

өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Саяын ажлын хэсэг үү? Ажлын хэсгийг дуудаж оролцуулъя. Дуудъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төсөлтэй холбогдуулан санал асуулга асууж болно гэсэн байгаа. Алив, энэ саналуудыг эхлээд. Ингээд хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлъя.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2 санал байсан.

2.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэнэ.

Засгийн газар дахь Хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

2.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна. Байна уу? За Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Учрал сайд аа бид нар энэ ноднин өнгөрсөн парламентад энэ Мэргэжлийн хяналтыг татан буулгасан. Тэгээд хяналт шалгалтыг тухайн яамнуудад нь харьяалуулахаар ингэсэн. Энэ хяналтын тогтолцоо ер нь яаж ажиллаж байна? Мэргэжлийн хяналтын байцаагч нар гэж байсан. Босоо тогтолцоотой, босоо байгууллагуудтай харьяалагддаг болсон. Энэ албан хаагчдыг ерөөсөө харьяалдаг, зарим нэг нь орох оронгүй ч явж байгаа юм шиг байна лээ. Нөгөө цалингийн нэмэгдэл юмнууд нь, орон нутгийн 20 хувийн нэмэгдэл юмнууд нь хамрагдаж байгаа юу, үгүй юү? Үйл ажиллагааных нь хөтөлбөр, төлөвлөгөөг хэн баталдаг юм, хяналт шалгалтаа орон нутагтаа яаж хийж байгаа юм, тайлангаа яаж хэнд тавьж байгаа юм гээд? Асуудал бол орон нутагт байдаг хэвээрээ байгаа шүү дээ. Бид нар бол хяналт шалгалтын энэ тогтолцоог нь өөрчилчихсэн. Одоо бараг орон нутагт хяналт, шалгалт хийхгүй болчихсон. Хяналт, шалгалтгүй болчихсон гээд дур дураараа аашилж байгаа, авирлаж байгаа зүйлүүд байна уу, үгүй юү? Хяналт шалгалтгүйгээс болоод янз бүрийн эрсдэл гарах асуудал үүсвэл хэн хариуцлага хүлээх вэ гээд ингээд асуудлууд зөндөө байна. Энэ дээр хариулт өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: 2023 оны 1 дүгээр сарын 1-нд энэ Засгийн газар дээр Хяналтын тухай хууль батлагдаад энэ салбарын хяналтууд салбарын яамнууд руу шилжсэн. Үүнтэй холбогдуулаад хуучин тэр мэргэжлийн хяналтын байгууллага байсан, ажиллаж байсан байцаагч нар

бол салбарынхаа яаман дээр тэр салбарын хяналтын газраас улсын ерөнхий байцаагчийнхаа эрхийг аваад чиг үүргээ хэрэгжүүлж байгаа.

Өнгөрсөн хугацаанд бол ийм Хэрэг эрхлэх газрын дэргэд тэгээд дэд дарга, тэр салбарын хяналтын байгууллагыг удирддаг ийм статустай байсныг энэ Засгийн газрын үед бол Үндэсний хорооны түвшинд авчраад бие даасан ийм сайдтай болгосон.

Тэгэхээр Хяналт шинжилгээний Үндэсний хорооны дарга Монгол Улсын сайд бол энэ салбарын хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, байцаагчийн эрхийг нь олгох, тэр салбарын хяналтуудыг чиг үүргийн хувьд зөв зохион байгуулах ажлыг бол гардан зохион байгуулна. Энэ утгаараа бол сая энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хууль орж ирэх үеэр энэ салбарын хяналтын газрыг Засгийн газрын ийм хэрэгжүүлэгч агентлагийн хэмжээний статустай болгочихсон байсан. Яг ийм хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар бусад агентлагуудын статустайгаар ажиллаад хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ гэдэг бол боломжгүй.

Тийм учраас бид бол энэ Хэрэг эрхлэх газрын яг ийм шатлалаар цалинждаг тийм тухайлсан статустай ийм байгууллагаар нь авч үлдээд, тухайн Монгол Улсын сайд, Хяналт шинжилгээний Үндэсний хорооны дарга бол тухайн байгууллагаа удирддаг ийм тогтолцоо руу шилжиж байгаа юм. Тэгэхээр салбарууд дээр байдаг нөгөө хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар бол мэдээж мэдээллүүдээ нэгтгээд, дотоод аудит үнэлгээгээ хийгээд, Хэрэг эрхлэх газар нь нэгтгээд, Засгийн газрын хуралдаанаар асуудлаа оруулдаг чиг үүрэг угаасаа яамнуудад байгаагаараа байгаа ч гэсэн энэ хяналт шинжилгээний үнэлгээний асуудлыг ч энэ салбарын хяналтын Үндэсний хороо хариуцна, дээрээс нь салбарын хяналтын

асуудлыг ч хариуцна гэхээр яг ийм Үндэсний хорооны түвшинд илүү бас нэг цогц бодлоготойгоор явах чиглэл рүү нь хандуулах зорилгоор ийм Үндэсний хороог тухайлан байгуулаад ийм салбарын сайдтай болсон.

Тэгэхээр маш их мэдээж хүлээлт байгаа. Яг одоо энэ Сандаг гишүүний яг хэлж байгаагаар үнэхээр энэ салбаруудын хяналтын тэр байцаагч нарыг мэргэжил арга зүйгээр хангадаг, тэдгээр хүмүүст чиг үүрэг өгдөг, удирдамж өгдөг ийм чиг үүрэг бас орхигдоод удсан.

Тийм учраас энэ Мэргэжлийн хяналтыг анх л энэ татан буулгахдаа бол төрийн хүнд суртлын бууруулах, олон ийм хяналтын чиг үүргүүдийг багасгах, хувийн хэвшил дээр очоод байгаа энэ хүндрэлүүдийг бууруулах гэдэг зорилгоор л энэ чинь буусан шүү дээ. Тэгэхээр одоо бол цаашидаа хяналтын асуудлыг эрхэлсэн салбарын сайд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу? Болох уу?

Ер нь бол бид нар анх хэлэлцэж байхад яг энэ хуулийг хэлэлцэж байхад бас арай ондоо түвшиний, өндөр түвшин дээрээс бас удирдаж хяналт тавихгүй бол нэг түвшинд орчихоороо хяналтаа хийж чадах уу, үгүй юу гэдэг асуудал бас яригдаж байсан шүү дээ. Тэгэхээр Учрал сайд наад чинь Засгийн газар дээрээ ингээд шийдвэр гаргаад үндсэндээ болно гэж үзэж байна уу тээ? Яг саяын Үндэсний хороо байгуулагдаад явчихаар бусад яамнуудтайгаа ямаршуу хэмжээний түвшинд харьцах тийм боломж, бололцоо гарч ирж байна? Хамгийн гол нь бас тодорхой хэмжээний хяналт явуулах, удирдах түвшинд ажиллахгүй бол бас хүндрэл гарах гээд байгаа шүү дээ. Энэ дээр хариулт авъя.

Н.Учрал: Засгийн газар дахь Хяналтын хуулиар мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, үйл ажиллагааны хяналт тавих, зохицуулах, улсын

хэмжээний хяналт, үнэлгээг хариуцах эрх бол энэ Монгол Улсын сайд, Хяналт шинжилгээний Үндэсний хорооны даргад шилжсэн.

Тэгэхээр хуучин бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байсан тэр хяналт шинжилгээний чиг үүргүүд бол тэр Хяналт шинжилгээний Үндэсний хорооны дарга Монгол Улсын сайд цаашидаа эрхэлнэ. Мэдээж Засгийн газрын хуралдаанаар орох танилцуулах зүйлээ бол бусад яамнуудтайгаа адилхан аваад л явна.

Тэгэхээр цаашидаа бол салбарын хяналтын чиг үүргийг зөвхөн Монгол Улсын сайд, Хяналт шинжилгээний Үндэсний хорооны дарга хариуцна л гэж ойлгож болно. Энд салбарын хяналтууд ч хамаарна, дээрээс нь яамнуудын хяналт шинжилгээ, дотоод аудит ч хамаарна. Тэгэхээр бид бол салбарын, Засгийн газрын түвшинд нийт хяналт шинжилгээний үнэлгээ буюу нөгөө [inelvee.gov](http://inelgee.gov) дээр нэгтгэдэг үнэлгээний функцүүдийг яг энэ салбарын хяналтын Үндэсний хорооны даргад, дээрээс нь салбарын хяналтын чиг үүргүүдийг бас даргад нь ингээд шилжүүлж байгаа гэсэн үг. Тэгэхээр 2 үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлээд явна.

Сая Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хууль оруулж ирэх үеэрээ энэ төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч дотор энэ салбарын хяналтын хэрэгжүүлэгч агентлаг байгуулчихсан байсан. Яг ингээд явах юм бол яг нөгөө бусад хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар энэ салбарын хяналтын байгууллага ажиллах юм бол энэ байгууллага өөрөө яамнуудыг хянах, үнэлэх ийм эрх байхгүй байхгүй юу.

Тийм учраас бид энэ бүдүүвчээс гаргаад энэ бол Үндэсний хорооны түвшинд ажиллах юм байна, сайд хариуцах юм байна, дэргэд нь энэ байцаагчийн эрхээ олгож байгаа салбарын хяналтын чиг үүргээ

хэрэгжүүлж байгаа байгууллага ажиллана гэдэг зохион байгуулалтыг бол хийсэн гэж хэлж болно. Тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслийн 2 дугаар зүйл дээр өөр асуулт, хариулт, асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр, асуулт саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

3.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Кнопоо, кнопоо дараарай. Эрдэнэбат гишүүн ээ наадах чинь шууд орохгүй юу? 3 болно л доо. Хуруу хийгээд наад юугаа ажиллуул даа. Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэбат: Нэг санал байгаа. Яаж орж байгаа вэ гэдэг талаар бас нэмээд тайлбарлачихвал. Төрийн хяналт шалгалтын энэ хууль тогтоомж дээр сая мэргэжлийн хяналт гээд яригдлаа давхар олон нийтийн хяналт гэдэг дээр бас тодорхой төр өөрөө бас хийж чадахгүй байгаа хүний нөөцийн хувьд, зохион байгуулалт, мэргэжлийн хувьд хийж чадахгүй байгаа зүйлээ төрийн бус байгууллагуудад зарим чиг үүргийг нь бас хариуцуулах ийм чиглэлээр энэ хуулийн төсөл ер нь орж байгаа юу? Үзэл баримтлалын хувьд болон? Хуучин бол мэргэжлийн хяналтын зарим чиг үүргийг тухайлбал, хөдөлмөрийн хяналт, аюулгүй байдлын чиг үүргийг байгууллагад өгч байгаад дараа нь прокурорын саналаар тэрийг нь буцаагаад больчихож байсан юм. Ихэвчлэн нөгөө соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх гэдэг юм уу, мэдээлэх гэдэг энэ хяналтуудыг нь уул нь тэр чаддаг мэргэжлийн чиглэлийн ТББ-ынх нь оролцоог татан оролцуулж, олон нийтийн оролцоог оруулах байдлаар энэ хяналт эрсдэлийг хийвэл илүү их зохистой гэж би бас үздэг. Тийм учраас энэ талаар энэ хууль дээр яг тусаж байгаа юу, үгүй юү гэдэг тал дээр тусвал их сайн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя. Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Өнгөрсөн парламентад Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хууль батлагдсан. Тэгээд Мэргэжлийн нэгдсэн эрх зүйн байдлын хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг чиглэл бүрээр 1, 1 мэргэжлийн холбоо байгуулах ийм эрх зүйн боломжийг олгосон. Энэ хүрээндээ мэргэжлийн холбоодууд байгуулагдаад, мэргэжлийн холбооны их хурлаа зохион байгуулаад Улсын Дээд шүүхэд бүртгүүлэх ийм эрх зүйн зохицуулалттай.

Тэгээд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн мэргэжлийн холбоо байгуулагдсан тохиолдолд төрийн зарим

чиг үүргийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх ийм боломж нээгдэж байгаа. Тэгэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр бид Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулаад ажиллаж байна.

Тэгэхээр цаашидаа бол одоо яг сонгодог мэргэжлийн холбоодууд гэж нэрлэгдээд байгаа жишээ нь, Үйлдвэрчний эвлэл тусдаа хуультай байж болно, Хуульчдын холбоо байж болно, Өмгөөлөгчдийн холбоо гээд ийм мэргэжлийн холбоодууд бий. Тэгэхээр энэ байгууллагууд бол цаашидаа төрийн зарим чиг үүргийг шууд шилжүүлэн авах ийм эрх зүйн боломжтой. Ялангуяа энэ салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа.

Жишээ нь, зарим салбар дээр 4, 5 хуучин мэргэжлийн хяналтын чиг үүрэг хариуцаж байсан байцаагч нар салбарын яамнуудад ирчихсэн байна л даа. Тэгэхээр энэ хүмүүсийн ажлын ачаалал ч гэсэн төдийлөн хүрдэггүй. Бүхэлд нь салбарын хяналтыг хариуцахад. Тэгэхээр энэ хүмүүс 3,4-үүлээ нийлээд салбарын хяналтын чиг үүргийг хариуцаж бүрэн чадахгүй байгаа. Тэгэхээр энэ хүмүүс удирдамжаараа хангаад энэ хяналтын чиг үүргүүдийг, салбарын хяналтын чиг үүргүүдийг мэргэжлийн холбоонд нь шууд шилжүүлэх боломж бол одоо салбарын сайдуудад олгогдчихсон.

Тэгэхээр цаашидаа бол бид нар энэ хяналтын чиг үүргийг ялангуяа энэ зарим салбар дээр энэ мэргэжлийн зэрэг олгодог, сургалт хийдэг, тусгай зөвшөөрөл, лиценз олгодог энэ ажлуудыг ер нь мэргэжлийн холбоонд нь шилжүүлээд явъя гэдэг ийм л зорилгоор энэ Мэргэжлийн холбооны хуулийг баталсан учраас цаашидаа бол яг энэ Эрдэнэбат гишүүний хэлж байгаагаар энэ мэргэжлийн хяналт, салбарын хяналт энэ чиг үүргүүдийг ер нь мэргэжлийн холбоо руу шилжих рүү бид зохион байгуулалттайгаар, үе шаттайгаар явъя гэдэг ийм зорилгоор

энэ холбооны Мэргэжлийн холбооны хуулийн хэрэгжилтийг хангуулж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бас туссан байгаа байх тээ?

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр дахин асуулт, хариулттай гишүүд байна уу?

Алга байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Асуулт байна уу?

Алга байна.

Төрийн захиргааны байгууллагын, айн хаана байгаа юм? Өө уучлаарай таны наад юуг чинь асахгүй болохоор Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Төрийн захиргааны байгууллагуудын бүдүүвчийн тухай гээд бас энэ дээр Хэрэг эрхлэхийн сайдаас бас хамтатгаад тодруулаад асуучихъя. Ер нь энэ үйл ажиллагааны төлөвлөгөө болоод энэ тогтоолын төсөл дээр төрийн чиг үүргүүдийг ер нь энэ бид нар орон нутагт эрх мэдэл шилжүүлэх, төвлөрсөн удирдлага, эс төвлөрсөн удирдлага гээд ярьдаг. Энэ дээр яг

бодлогын ямар өөрчлөлтүүдийг, бодлогын ямар хандлагыг барьж байгаа вэ? Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын энэ төрийн захиргааны чиг үүрэг тэр тусмаа бүгдээрээ алхам алхмаар тогтоол бүрээр дамжсаар байгаад Улаанбаатараас хамаардаг л болчихсон. Одоо бараг орон нутагт байгаа, нэг аймагт байгаа 20 агентлагийн 18 нь гэлүү дандаа босоо томилгоотой, төсөв, төлөвлөгөө дандаа дээрээс явдаг. Тэгэхлээр энэ дээр ер нь бодлогын ямар өөрчлөлт ер нь энэ үйл ажиллагааны төлөвлөгөө болоод энэ тогтоолын төсөлд олон зүйл дээр орж байгаа вэ?

Жишээ нь, энэ зөвхөн төсвийг харахад Монгол Улсын 21 аймгаас 4 байна уу, 4-хан аймаг л өөрөө төсвөө бүрдүүлдэг. Бусад нь төсвийн татаастай. Тэгэхээр томилгоо боловсон хүчний бодлого бүгдээрээ дээрээс, төсөв төлөвлөгөө бүгдээрээ төвөөс татаас авдаг. Тэгэхлээр цааши цаашидаа энэ улс орон, энэ төрийн захиргаа, төрийн алба ингээд нэг ийм төвлөрсөн тогтолцоо руу аажим аажмаар эргэж орж. Өнгөрсөн 4 жил, өнгөрсөн 8 жилд энэ чиглэлээр л явж байсан.

Тэгэхээр энэ дээр тодорхой өөрчлөлт, бодлогын барьж байгаа чиглэл, тодорхой зүйл, заалтуудаасаа та мэдээлэл, тайлбар өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тэр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг, түүний удирдлагыг хэвтээ удирдлагатай болгох, ер нь аймаг, орон нутагт нь энэ чиг үүргийг нь шилжүүлэх чиглэлээр яг тодорхой зохицуулалтыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах гэхээр энэ нь өөрөө Үндсэн хуулийн өөрчлөлтийн концепцтой бас зөрчилдөөд байгаа юм.

Тийм учраас энэ өөрөө засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн асуудал учир бас бид энэ бас харьцангуй

улс төрийн шийдвэр байх ёстой гэдэг утгаар нь 3 намын гэрээн дээр яг Цогтгэрэл гишүүнээс гаргасан санал гэж би ойлгосон. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс орж ирсэн тэр саналаар нь 3 намын гэрээн дээр яг тусгаж өгсөн. Тэгэхээр бид бол цаашидаа энэ томилгоог ч гэсэн ер нь орон нутагт нь шилжүүлэх чиглэл рүү бодлого барина гэдгээ 3 нам бол улс төрийн шийдвэрээ би гаргачихсан гэж ойлгож байгаа.

Тэгэхээр цаашидаа ямар эрх зүйн орчны шинэчлэл хийх вэ гэдэг дээр бид хамтраад ажиллахад бол нээлттэй. Мэдээж Засгийн газрын хөтөлбөрт бол өөрөө энэ эрх зүйн шинэтгэл, Үндсэн хуулийн бүүр шинэчлэл, реформтой холбоотой асуудлыг иүүд хөндөж бол болохгүй. Тийм учраас тухайлан заагаагүй.

Гэхдээ энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол өөрөө бүхэлдээ 2 дугаар бүлэг өөрөө эдийн засгийн эрх чөлөө гэдэг бүх агуулга бол тэр дотроо бол төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй гэдэг үндсэн суурь зарчмаа барья гэж зорьсон.

Дээрээс нь төрийн чиг үүргийг мэргэжлийн холбоонд үе шаттайгаар шилжүүлнэ гэдэг ийм л зорилгыг барьж байгаа. Тэгж түүний үндсэн дээр цомхон, чадварлаг, бүтээмжтэй төрийг бий болгоно.

Тэгэхээр миний хувьд ч гэсэн ер нь 16 оноос хойш парламентад ажилласнаасаа хойш бол ерөөсөө л гол баримталсан зарчим бол энэ Мэргэжлийн холбооны хуулийг гаргаад, төрийн шийдвэр гаргалтад мэргэжлийн экспертүүд оролцох боломжийг нь мэргэжлийн холбоогоор нь нээе л гэж зорьсон. Тэрнээс биш тэр мэргэжлийн экспертүүд, эрдэмтэн, судлаачид заавал яаманд орж ирээд мэргэжилтэн болох шаардлага бас төдийлөн байхгүй.

Харин мэргэжлийн холбоондоо ороод зарим хууль, эрх зүйн орчныг

сайжруулах ажил дээр гэрээгээр ажиллаж болж байна. Шийдвэр гаргалтад нь зөвлөөд ажиллаж болж байна.

Жишээ нь, мэргэжлийн холбоо байгуулаад тэр сертификатжуулах, сургалт зөвлөгөө хийх, тусгай зөвшөөрөл олгох бүх ажлыг мэргэжлийн холбоондоо ороод хийж хэрэгжүүлж болж байна. Тэгэхээр ер нь бол мэргэжлийн холбооны хуулиа ерөөсөө амилуулья, салбар болгон дээр мэргэжлийн холбоодуудыг нь байгуулья. Ингээд ТББ гэж нэг даргын, нэг хүний кармад 3, 4 тамгатай байдаг төрийн бус байгууллагуудад итгэхээс илүүтэйгээр дунд нь зөвшөөрөгдсөн мэргэжлийн холбоог нь байгуулаад л Дээд шүүх бүртгэсэн тэр байгууллагад нь чиг үүргийг нь шилжүүлъя. Ингээд цомхон, чадварлаг төртэй болохгүй бол цаашидаа бол бид нар явах зам их байхгүй болж байна.

Тийм учраас Засгийн газрын бодлого бол төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбооноосоо шилжүүлнэ, хувийн хэвшилээ дэмжье л гэсэн ийм л бодол.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Тийм ээ. Яг энэ дээр асуулт бол алга. Тодруулаад нэмээд саналаа хэлэхэд би гуравхан зүйлийг л хэлчихье. Орон нутагт эрх мэдэл гэдэг, орон нутагт эрх мэдэл гэж бид нар зөндөө л ярьдаг. 10, 20 агентлагийн 18 нь төвөөс босоо томилгоотой, 21 аймгаас 5-хан аймаг нь төсөв бүрдүүлдэг, бусад нь бүгд татаастай. Тэгэхээр энэний цаана орон нутгийн эрх мэдэл, орон нутгийн хөгжил дэвшилд оролцоо гэдэг юм ямар түвшинд байгааг л энэ бүгд харуулж байгаа. Одоо дахиад сар гарангын дараа орон нутгийн сонгууль болно. Одоо сонгуулиар дахиад юу болдог билээ аймаг, сумын ИТХ гэдэг байгууллагыг бид нар сонгодог. Яг үнэндээ ИТХ гэдэг байгууллага биш энэ өөрөө намуудын төлөөлөгчдийн хурал

гэдэг байгууллага болчихсон. Намаас нэр дэвшүүлээд гоё иргэдийн хурал гэдэг гоё нэртэй. Тэгэхээр яг одоо энэ ярьж байгаа энэ үзэл баримтлал, концепцын хүрээнд бид нар энэ орон нутгийн эрх хэмжээ гэдэг энэ зүйлээ тэр улс төрийн эрх мэдлийг нь, санхүүгийн эрх мэдлийг нь, боловсон хүчний эрх мэдэл дээр эргэж харж энэ үйл ажиллагааны төлөвлөгөө болоод энэ орж байгаа энэ бодлого чиглэлээ бүхэлд нь бид нар эргэж харахгүй л бол ерөөсөө ийм төвлөрсөн төлөвлөгөөт Улаанбаатар төвтэй ийм л улс л болчихож байгаа юм. Тэгэхээр энэний цаана олон олон зүйл л бид нар боломж алдаж байгаа, томоохон суурь өөрчлөлтүүдээ хийх ёстой ийм л хэрэгцээ шаардлагыг л бид нарт харуулж байна л гэж ойлгодог. Тэгээд цааш цаашидаа бас тал талдаа анхаарч ажиллана биз дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд энэ үйл ажиллагааны хөтөлбөр дотор чинь энэ орж ирсэн үү заалт? Учрал сайд хариултыг хариулъя.

Н.Учрал: Ер нь бол 3 намын тэр гэрээн дотор бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж засаг захиргааны нэгжийн хуваарьт өөрчлөлт оруулж, гүйцэтгэх эрх мэдлийн зарим томилгоог орон нутаг руу шилжүүлэх бодлого барина гээд ер нь бол тохиролцоонд хүрлээ гэж бид ойлгосон. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бол Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлнэ л гэж ерөнхий концепц барьж байгаа. Тэр бол бие даасан эдийн засаг бүхий дагуул хот гээд өнгөрсөн парламентын үед бид нар чинь бас богино хугацаанд баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг харахад бол бас зарим сайн заалтууд байна. Одоо бас их шинэчлэл мэдрэгдэж болохуйц.

Яагаад гэхээр үүний дагуу бол орон нутагт орон нутгийн чанартай хотууд бараг 45 хот бие даасан төсөв мөнгөө захиран зарцуулдаг, татвараа бүрдүүлдэг ийм хотууд байгуулагдана. Улсын зэрэглэлтэй хотууд байгуулагдана

гээд ингээд эхлэхээр ер нь бараг 50 гаруй нэгж байгуулагдах юм. Тэгэхээр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг бид хангаад, шаардлагатай өөрчлөлтийг ч гэсэн 26 оны 1 сарын 1-нээс өмнө хийгээд засаж залруулаад явчхаж болно.

Гэхдээ том урагшилсан. Цаашидаа бол ерөөсөө л энэ орон нутгийн бие даасан байдлыг хангуулахаар л энэ хуулийг хийсэн. Тэгэхээр энэ бол Улаанбаатар хотын хувьд ч гэсэн, орон нутгийн хувьд ч гэсэн ийм бие дааж хөгжих бололцоо бол бүрдэж байгаа.

Дээрээс нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулна гэдгийн хамгийн гол зорилт бол анх удаа ер нь бүс өөрийн онцлогт тохируулсан ийм ялгаатай татварын бодлого хэрэгжүүлнэ гэдэг маш том урагшилж байгаа хэлбэр байхгүй юу. Өмнө нь бол бид нар ялгаатай татварын бодлого гэж бараг ингэж оруулж ирж байгаагүй шүү дээ.

Тэгэхээр бүсчилсэн хөгжлийн хүрээнд ийм ялгаатай татварын бодлого явна. Бие даасан эдийн засаг бүхий дагуул хотууд, орон нутгийн чанартай хотууд, улсын зэрэглэлтэй хотууд гээд 45, 6 нэгж байгуулагдана гэхээр орон нутаг бие даан хөгжих нөхцөл, бололцоо үүснэ. Үүний хүрээнд бол бас багагүй асуудлууд шийдэгдэнэ гэж ойлгож байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүний саналыг дахиад тодруулъя Учрал сайд аа.

Яг үнэндээ орон нутагт бол Засаг даргын үйл ажиллагааны хүрээнд шууд дуудаад үүрэг даалгавар өгөөд харцуцлагажуулах ийм тохиолдол бол аягүй суларчхаад байгаа шүү дээ. Ерөөсөө 2-оос 3 агентлаг л үлдэж байгаа байх тэр дотор. Бусад нь бол өөдөөс нь бараг л уучлаарай бид нар бодлого ондоо явж байгаа, таны бодлоготой нийцэхгүй гээд өөдөөс нь ийм хариултыг хэлээд явж сууж байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр бүгдээрээ босоо руу орчхоод 1-ээс 2 байна уу, 2-оос 3 байгаа байх. Агентлаг нь бол яг Засаг дарга өөрөө харууллага тооцдог, томилдог ийм агентлаг болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар бол орон нутгийн төвлөрлийг сайжруулна, орон нутаг бие даах бололцоог олгоно гэсэн бодлого яриад байгаа мөртөөрөө хэрэгжүүлэх механизм, би чуулган дээр асуугаад байсан шүү дээ сайхан сайхан зүйлүүд энэ чуулганы танхимд ярьчхаад яг хэрэгжүүлэхдээ сайд нар нь очоод далий юм яриад байдаг ийм механизм чинь өөрөө, хэрэгжүүлэх механизм чинь болж өгөхгүй байна, энийгээ сайн тодруулж өгөөч гээд миний яриад байсан асуудал чинь энэ байхгүй юу.

Тэгэхээр яг Цогтгэрэл гишүүний ярьж байгаа асуудалтай холбоотой би андуураад байна уу Цогтгэрэл гишүүн хэлсэн үү, хэн хэлсэн үү чуулган дээр наад асуудал чинь бас яригдсан байхгүй юу. Тэгээд яригдсан шүү дээ. Ер нь бол эрх мэдлийг, төвлөрлийг сааруулъя, тэгээд орон нутгийн эрх мэдлийг бас нэмэгдүүлье гэж үйл ажиллагааг нь орон нутагтаа явуулах ийм боломж, бололцоог нь нэмэгдүүлье гэсэн ийм зүйл яригдсан даа уг нь бол.

Хэрвээ шаардлагатай байгаа бол одоо бид нарын энэ мөрийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа, хэлэлцэж байгаа нөхцөл байдал ажлын хэсэг дээр наадхыг чинь өөрчлөөд бид нар саналаа оруулах бололцоо байгаа шүү дээ. Тийм лоозон болчхоод байна.

Учрал сайд.

Н.Учрал: Энэ жишээ нь, аймгийн нэг хэлтсийн даргыг сайд томилдог байдлыг одоо болиулах хэрэгтэй. Тэгээд би энэ дээр бол Бат-Эрдэнэ гишүүнтэй, Цогтгэрэл гишүүнтэй санал нэг байгаа. Тэгэхээр 3 нам үнэхээр тэр хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулахдаа тэр засаг захиргааны нэгжийн хуваарьт өөрчлөлт оруулна, хэвтээ томилгоо руу

шилжинэ гэсэн энэ рүү хамт явах л ёстой.

Жишээ нь, тэр Хот, тосгоны хууль дээр бид яг Цогтгэрэл гишүүн санаж байгаа байх тухайн үед боловсролын томилгоог орон нутагт хийе гэхэд л бас гэдийгээд суучихсан, эрүүл мэндийн салбарыг орон нутагт нь өгье гэхээр л гэдийгээд суучихсан. Ер нь бол ерөөсөө яадаг вэ гэхээр ийм юм байх юм аа ингээд ажил авахаараа ингээд мөнхийн тэр ажлыг хийх юм шиг сэтгэдэг ийм дарга нарын сэтгэл зүйг халахгүй бол ерөөсөө ийм эрх мэдлээ ч салж өгдөггүй. Тэгээд хууль оруулаад ирэхээр үгүй би энэ томилгоог өгөхгүй гээд ингээд суучихдаг. Тэгээд л Их Хурал дээр орж ирээд л уначихдаг. Үнэхээр улс төрийн шийдвэр гаргаад бид засаг захиргаа, нэгжгийнхээ хувиарт өөрчлөлт оруулна л гэсэн бол энэ рүү яваад тэр орон нутаг бие даан хөгжих бололцоог нь хангах ёстой.

Гэхдээ Монгол Улс бол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс. Тэгэхээр тэр аймаг, орон нутгийн Засаг даргыг тэр Ерөнхий сайд батламжлах, тэр бодлогоо хэрэгжүүлэх, Засаг дарга нар Засгийн газрын өмнө үйл ажиллагаагаа бас тайлагнах тэр механизм байлгүй яах вэ. Гэхдээ тэр Засаг даргыг бие дааж орон нутгаа хөгжүүлэх бололцоог нь олгохгүйгээр бол цаашдаа явахгүй болсон.

Тэгэхээр ийм нэгэнт улс төрийн 3 намын зөвшилцлийн хүрээнд энэ асуудал орсон учраас орж ирж байгаа хуулиуд дээр ч гэсэн зөвхөн энэ ажлыг би өнөөдөр хийнэ гэдгээр байдлаар биш, энэ улс оронд илүү хэрэгцээтэй гэсэн байдлаар энэ эрх мэдлээсээ салж өгөхгүй бол яг өчигдөр нэг юм ярьж байсан хүн маргааш нэг өөр ажил авахаараа тэс өөр хүн болчихоод байгаа тохиолдлууд багагүй байгаад байна л даа. Тэгэхээр энэ дээрээ нэгдээд л урагшаа хараад явъя л гэж хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд санал нэг байгаа юм байна шүү. Тэгэхээр энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлж байгаа яг одоо хэлэлцэж байгаа энэ явцад саналаа оруулах боломж, бололцоо байгаа шүү дээ Цогтгэрэл гишүүн ээ. Ингээд цаашаа хэлэлцээд явъя.

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар дарга гишүүн дахиад танилцуулаад явчих уу? Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн захиргааны байгууллагын

тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Гуравдугаар асуудалдаа оръё.

17.28 цаг

**“Ажлын хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл.**

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Энэ Дэгийн тухай хуулийг бас та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126.5, Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална гэж байгаа шүү.

Тэгээд энийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах төслийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, “Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.5 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн гишүүд Ж.Баярмаа Улсын Их Хурлын гишүүн, П.Сайнзориг Улсын Их Хурлын гишүүн, Х.Тэмүүжин

Улсын Их Хурлын гишүүн, Б.Хатантуул Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх, Ж.Бямбадулам Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх, Б.Нандингэрэл Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх, Ж.Монголжингоо Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх, Нарийн бичгийн дарга, Х.Хэрлэн Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт.

2. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журам батлах тогтоолын төслийг 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор боловсруулж танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

Төрийн байгуулалтын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ гэсэн байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулттай гишүүд байна уу?

Алга байна.

Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

68 хувиар тогтоол батлагдлаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

17.32 цаг

**Дөрөв дэх асуудал руу оръё.
Горимын санал дэвшүүлээд дэмжигдсэн санал байж байгаа. Хэлэлцэх асуудал “Дэд хорооны бүрэлдэхүүн өөрчлөх**

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тогтоолын төсөл танилцуулагдсан уу? Би уничиx уу?

Улсын Их Хурлын тогтоол, “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг тус хорооны гишүүнээр баталсугай.

2. Тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэж.

Энэ тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна. Миний бие өөрийнхөө нэрийг татаад Халдашгүй байдлын дэд хороо 9 гишүүнтэй байгаа. Тэгээд миний биеийг хүсэлтээрээ нэрээ татаад Жамбалын Ганбаатарыг оруул гэсэн ийм саналыг оруулаад энэ тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт байна уу?

Алга байна.

Туваан гишүүн.

Ц.Туваан: Хэдэн, хэн хэн байдаг юм бол? Бүрэлдэхүүнийг нь сонсож болох уу? Дээрээс нь энд ороход ямар нэгэн тусгай шалгуур янз бүрийн юм байгаа

юу? Тэрийг нь хэлээд өгөөдхөөч. Харин тийм царай хардаг юм уу, юу хардаг юм.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Норовын Алтанхуяг, Халтмаагийн Баттулга, Жадамбын Бат-Эрдэнэ, Сандагийн Бямбацогт, Лувсаннъямын Гантөмөр, Цэрэнпилийн Даваасүрэн, Баттогтохын Чойжилсүрэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Жадамбын Энхбаяр гэсэн 9 гишүүн байгаа.

Улсын Их Хурлын үгүй ээ, үгүй үгүй. Би Дэгийн тухай хууль танилцуулаадахья та бүхэнд.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27.8 Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон 9 гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллөөс оруулна. Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийг харьяалагдах нам, эвслийн бүлгийн саналыг баримтална гэж. Энэ бол Улсын Их Хурлын тогтоолоор бол батлагдсан байгаа. Одоо ингээд өөрчлөлт оруулж байгаа юм. Санал хураалт авна. Томьёолол хаана байна? Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд санал дэмжигдлээ. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал,
дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд
Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар
гишүүн дахин, Болормаа гишүүн
танилцуулаарай. Болормаа гишүүн
танилцуулна.

17.36 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР